

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.Монгол Улсын Их Хурал 2022 оны 54 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт-тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

2.Монгол Улсын Их Хурал 2022 оны 34 дүгээр тогтоолоороо “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээ”-г иргэний эвлэлдэн нэгдэх эрхэд Үндсэн хуулиар тавьсан хязгаарлалтыг арилгах, иргэн үндсэн эрхээ хуульд заасан хязгаарын хүрээнд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж хамгаалуулах боломжтой болох, Үндсэн хуулийн цэцийг аливаа улс төрийн нөлөөллөөс хараат бус байх, Үндсэн хуулийн шүүхийн хувьд ажиллах зарчмыг гүнзгийрүүлэн бэхжүүлэх, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх, нийслэлийн эрх зүйн байдлыг оновчтой болгох, төвлөрлийг сааруулах зэрэг асуудлыг багтаан тогтоосон.

3.Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатайгаар тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх зорилгоор Улсын Их Хурлаас 2023 оны 1, 2 дугаар сард зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын дүнг үндэслэн гаргасан зөвлөмжид иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх талаар, Улсын Их Хурлын сонгуулийг явуулахдаа олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулах нь зүйтэй талаар, улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзах талаар тус тус дэмжсэн дүн гарсан.

Эдгээр хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд дараах асуудлыг тусгана:

1.Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэгтэйн хувьд иргэний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэх боломжтой байхаар Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан ч уул маргааныг Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект болгон хуульд шууд зааж өгөөгүй, явцууруулан ойлгож ирсэн. Үндсэн хуулийн цэц нь иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчил /халдашгүй чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх гэх мэт/-ийг авч хэлэлцэхгүй байгаагаас Монгол Улсад иргэний үндсэн эрхийг зөрчсөн тохиолдлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна. Иймд шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн бол иргэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж болох, улмаар Үндсэн хуулийн цэц уул маргааныг магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргах зохицуулалтыг тодруулан заана.

2.Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй ч өнгөрсөн 31 жилийн хугацаанд нэг ч удаа гаргаж байгаагүй. Учир нь Улсын Их Хурал дахь олонхын зүгээс хууль тогтоомж Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл өөрөө өөрчлөх бүрэн эрхтэй тул Үндсэн хуулийн цэцэд хандах шаардлагагүй байв. Иймд парламентын олонхын баталсан хууль тогтоомж нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд цөөнх энэ талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж маргаан үүсгэх боломжийг нээх, олонхын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэхэд тавих хяналтыг үр нөлөөтэй болгохтой холбогдсон зохицуулалтыг тодруулан төсөлд тусгана.

3.Иргэд хууль тогтоомж дахь хүний эрхийн зөрчлийн асуудлаар шүүхэд хандахаас илүү Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол, мэдээлэл гаргахад хялбар, нээлттэй байдаг. Иймд уг комисс иргэдийн гомдол, мэдээллийг мэргэжлийн үүднээс хянаж, хууль тогтоомж хүний эрх зөрчсөн асуудлыг Үндсэн хуулийн цэцэд өгч (абстракт хяналт) шийдвэрлүүлдэг байх бүрэн эрхийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст олгохоор төсөлд заана.

4.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр дахин томилоход ямар нэгэн хязгаарлалт байхгүйгээс олон удаа томилогдож 18, 26 жилээр ч ажиллах тохиолдол гарч байв. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нэг удаа урт хугацаагаар томилох, эсхүл нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох нь уул шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахад чиглэсэн эрх зүйт төртэй улсуудын сайн туршлага юм. Иймд, Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил хэвээр нь байлгахын зэрэгцээ нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох (нийт хоёроос илүүгүй бүрэн эрхийн хугацаанд ажиллах) заалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулахаар төсөлд тусгана. Ингэснээр Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх, өндөр мэргэшсэн хүнийг тогтвортой ажиллуулах ач холбогдолтой.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэсэн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцно. Учир нь энэ заалтаар улс төрийн нам байгуулахад хэт өндөр босго тогтоосон<sup>1</sup> нь иргэний эвлэлдэн нэгдэхийг зөрчих, улмаар төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Энэ нь улс төрийн олон ургалч байдлыг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлыг бий болгохоор байна. Түүнчлэн өмнө байгуулагдсан намуудад давуу боломжийг олгох нь ардчиллын зарчимд үл нийцнэ.

6. Мажоритар сонгуулийн тогтолцоо нь иргэдийн санал гээгдэх, тойргийн явцуу ашиг сонирхол улс орны эрх ашгаас өндөрт тавигдах, олон нийтэд танигдсан, хөрөнгө санхүүгийн боломжтой хүмүүст давуу байдал үүсгэх зэрэг сөрөг талыг бий болгож ирсэн. Пропорциональ аргыг сонгуулийн тогтолцоонд хэрэглэх нь сонгогчдын санал гээгдэхгүй байх, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл орох, бодлогын намыг төлөвшүүлэх зэрэг давуу талтай. Иймд, мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн холимог тогтолцоо гэж үзэж холбогдох зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд тусгаж, сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангана.

7. 1991-1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж батлах үед Улсын Их Хурлын гишүүдийн тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөхөөр тооцоолж, 76 гишүүнтэй байхаар хуульчилсан. Харин өнөөдөр нэг гишүүн дундажаар 44.7 мянган иргэнийг төлөөлөх болсон. Энэ нь нэг гишүүний төлөөлөх иргэдийн тоо бараг хоёр дахин нэмэгдэж, парламентын төлөөлөх чадамжийг бууруулж байна. Хэт цөөн гишүүнтэй парламентын хувьд хууль тогтоомж цөөн хүний үзэмжээр батлагдах, нэг гишүүнд эрх мэдэл төвлөрөх, зүй бус нөлөөлөл орох, хуулийн чанар муудах, хуулийн биелэлтэд тавих хяналт сулрах эрсдэл үүсдэг. Парламентын засаглалтай олон улсад парламент дунджаар 150-аас доошгүй гишүүнтэй байдаг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангахад чиглэдэг байна. Тиймээс иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэхээр төсөлд тусгана.

8. Төрийн дээд байгууллагуудыг улсын нийслэлд заавал байх зохицуулалтыг өөрчилж, төрийн зарим байгууллагыг нийслэлээс нүүлгэх эрх зүйн үндэслэлийг бий болгохоор төсөлд тусгана. Энэ нь төрийн зарим байгууллага Улаанбаатар хотоос нүүх, түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, хөдөөгийн сэргэлтийг дэмжиж хот, хөдөөгийн ялгааг багасгах ач холбогдолтой.

<sup>1</sup> Ардчиллыг хуулиар бэхжүүлэх Европын комисс (Венецийн комисс) болон ЕАБХАБ-ын ардчилсан институт, хүний эрхийн алба (ЕАБХАБ/АИХЭГ) зэрэг олон улсын байгууллагаас Намыг сонгогчийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулах нь эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж буй тул халах талаарх зөвлөмжийг Монгол Улсад удаа дараа ирүүлж байсан. Жишээлбэл, намыг бүртгүүлэхээс өмнө цуглуулах гарын үсгийн доод хэмжээ нь Андоррад 3 байхаас өгсүүлээд Хорват 100, Латви, Монтенегро болон Словенид 200, Словак болон Серби, Словак, Украинд 10.000 хүртэл өгсөн байна. Гэвч дээрх жишээнүүдийн аль нь ч нийт сонгогчийн 0.4 хувиас хэтрээгүй юм. *Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн төсөл дээр хийсэн ЕАБХАБ/АИХЭГ-ын Санал* (2019 оны 11 дүгээр сарын 27, Варшав хот), 13; Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн төсөл дээр хийсэн ЕАБХАБ/АИХЭГ-ын санал, CDL(2022)021.

**Гурав.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн  
төсөл батлагдсан дараа үүсэж болох нийгэм,  
эдийн засгийн үр дагавар**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл батлагдсанаар иргэний эвлэлдэн нэгдэх эрхэд Үндсэн хуулиар тавьсан хязгаарлалтыг арилгах, үндсэн эрхийн тодорхой зөрчлийн талаар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргах боломжийг нээх замаар иргэний үндсэн эрхийн баталгааг хангах, Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан байдал, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн ард түмнийг төлөөлөх парламентын чадавхыг сайжруулах, хууль тогтоомж болон хуулийн биелэлтэд тавих хяналтыг чанаржуулах замаар Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон парламентын засаглалыг төгөлдөржүүлэх болно. Монгол Улсын Үндсэн хуульд сонгуулийн холимог тогтолцоог тодорхой зааж баталгаажуулснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо тогтвортой байх, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаадад байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах сайн талтай. Түүнчлэн төвлөрлийг сааруулж хот, хөдөөгийн ялгааг багасгах, хөгжлийн нэг төвтэй улсаас олон төвтэй улс болгох нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

**Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн  
төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт,  
өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталж, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай зэрэг хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болно.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД  
ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ**

Төсөл

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Нэгдүгээр зүйл**

Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.”

**2/Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.”

**Хоёрдугаар зүйл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн дээд байгууллагууд” гэснийг “төрийн эрх барих дээд байгууллага” гэж, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “томилно” гэснийг “томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно” гэж, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр” гэснийг “Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**Гуравдугаар зүйл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**Дөрөвдүгээр зүйл**

**Дагаж мөрдөх хугацаа**

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

### I. ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГААГ ХАНГАХ

**Нэг. Хүний эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх:**

“66.1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай маргааныг уул эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэний өргөдлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана.”

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь иргэний үндсэн эрхийн тодорхой зөрчил /халдашгүй чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх гэх мэт/-ийг авч хэлэлцэх эрх зүйн орчин байхгүй. Үүнээс үүдэн Монгол Улсад иргэний үндсэн эрхийг зөрчсөн тохиолдлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна. Иймд шүүхэд хандсан, эсхүл хуулийн бусад аргыг хэрэглэсэн ч үндсэн эрх нь сэргээгдээгүй гэж үзсэн бол иргэн Цэцэд өргөдөл гаргах зохицуулалтыг тодорхой болгохоор төслийг боловсруулсан. Энэ заалт батлагдсанаар Цэц үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хууль хэрэглэж шийдвэрлэх, улмаар хүний эрхийн баталгаа нэмэгдэх ач холбогдолтой.

“66.2. Үндсэн хуулийн цэц нь Улсын Их Хурал, түүний нийт гишүүний аравны нэгээс доошгүй гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.”

Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурал Цэцэд хүсэлт гаргах боломжтой ч өнгөрсөн 31 жилийн хугацаанд нэг ч удаа гаргаж байгаагүй. Учир нь Улсын Их Хурал дахь олонх нь хууль тогтоомж Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл өөрөө өөрчлөх бүрэн эрхтэй тул Цэцэд хандах шаардлагагүй байв. Иймд парламентын олонхын баталсан хууль тогтоомж нь Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд цөөнх энэ талаар Цэцэд хүсэлт гаргаж маргаан үүсгэх боломжийг нээхээр төсөлд тусгав.

Мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын зүгээс хууль тогтоомж дахь хүний эрхийн зөрчлийн асуудлаар Цэцэд хүсэлт гаргах бүрэн эрхийг олгохоор тусгалаа. Иргэд шүүхэд хандахаас илүү тус комисст гомдол, мэдээлэл гаргахад хялбар, нээлттэй байдаг. Улмаар комисс гомдол, мэдээллийг мэргэжлийн үүднээс хянаж, хууль тогтоомж хүний эрх зөрчсөн асуудлыг Цэцэд өгч шийдвэрлүүлдэг болно.

“65.1.Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилох бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэгээс илүү удаа дахин томилохыг хориглоно.”

Цэцийн гишүүнээр дахин томилоход ямар нэгэн хязгаарлалт байхгүйгээс олон удаа томилогдож 18, 26 жилээр ч ажиллах тохиолдол гарч байсан. Иймд Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг 6 жил хэвээр нь байлгахын зэрэгцээ нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох заалтыг Үндсэн хуульд оруулах санал гаргав. Энэ заалт батлагдсанаар Цэцийн гишүүнээр хэт удаан ажиллахыг хязгаарлах, Цэцийн гишүүний хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх ач холбогдолтой. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нэгээс илүү удаа дахин томилохыг хориглох нь эрх зүйт төртэй улсуудын сайн туршлага юм.

#### **Хоёр. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай хангах:**

“19.12.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.” гэснийг хасах.

Улс төрийн нам байгуулахад хэт өндөр босго тогтоосон нь иргэний эвлэлдэн нэгдэх, төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Энэ нь улс төрийн олон ургалч байдлыг алдагдуулах, төлөөллийн ардчиллыг сулруулах, нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлыг бий болгохоор байна. Түүнчлэн өмнө байгуулагдсан намуудад давуу боломжийг олгох нь ардчиллын зарчимд үл нийцдэг.

## **II. АРД ТҮМНИЙГ ТӨЛӨӨЛӨХ ПАРЛАМЕНТЫН ЧАДАВХ, ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ**

#### **Нэг. Сонгуулийн холимог тогтолцоог тусгаж, иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлэх:**

“21.1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.”

Мажоритар сонгуулийн тогтолцоо нь иргэдийн санал гээгдэх, тойргийн явцуу ашиг сонирхол улс орны эрх ашгаас өндөрт тавигдах, олон нийтэд танигдсан, хөрөнгө санхүүгийн боломжтой хүмүүст давуу байдал үүсгэх зэрэг сөрөг талыг бий болгож ирсэн. Үүнийг шийдвэрлэх арга зам нь мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн холимог тогтолцоо юм. Үндсэн хуульд энэ тогтолцоог заах нь сонгуулийн хуулийг тогтвортой байлгах, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, иргэдэд ойлгомжтой байх, гадаадад байгаа иргэний сонгох эрхийг баталгаажуулах сайн талтай.

Монгол Улсын Үндсэн хуулийг анх батлах үед Улсын Их Хурлын гишүүний тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөх замаар 76 гишүүнтэй байхаар хуульчилсан. Харин өнөөдөр нэг гишүүн 44.7 мянган иргэнийг төлөөлж, бараг хоёр дахин нэмэгдэж, төлөөлөх чадамж алдагдахад хүрч байна. Хэт цөөн гишүүнтэй парламентын хувьд хууль тогтоомж цөөн хүний үзэмжээр батлагдах, нэг гишүүнд эрх мэдэл хэт төвлөрөх, зүй бус нөлөөлөл орох, хуулийн чанар муудах, хуулийн биелэлтэд тавих хяналт сулрах эрсдэл үүсдэг. Олон улсад парламент нь дунджаар 150-аас доошгүй гишүүнтэй байдаг. Тиймээс төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг хангах, иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэхээр төсөлд тусгав.

### III. ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ

**Нэг. Хөдөөгийн сэргэлтийг дэмжих, хэт төвлөрлийг сааруулж, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах:**

“13.1. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн.”

Төрийн дээд байгууллагуудыг улсын нийслэлд заавал байх зохицуулалтыг өөрчилж, төрийн зарим байгууллагыг нийслэлээс нүүлгэх эрх зүйн үндэслэлийг бий болгохоор төсөлд тусгасан. Энэ нь төрийн зарим байгууллага Улаанбаатар хотоос нүүх, түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, хөдөөгийн сэргэлтийг дэмжиж хот, хөдөөгийн ялгааг багасгах ач холбогдолтой.

### IV. ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА, ХҮРЭЭ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.